

**FreeBSD** гарын авлага

**FreeBSD** баримтжуулах төсөл

## FreeBSD гарын авлага

by FreeBSD баримтжуулах төсөл

Published 1999 оны хоёрдугаар сар

Copyright © 1995, 1996, 1997, 1998, 1999, 2000, 2001, 2002, 2003, 2004, 2005, 2006, 2007, 2008, 2009, 2010

FreeBSD баримтжуулах төсөл

Copyright © 2006, 2007, 2008, 2009, 2010 FreeBSD-г Монголоор баримтжуулах төсөл

FreeBSD-д тавтай морилно уу! Энэ гарын авлага нь *FreeBSD 7.3-RELEASE* болон *FreeBSD 8.0-RELEASE* хувилбаруудын суулгацаас эхлээд өдөр тутмын хэрэглээг тайлбарласан билээ. Энэ гарын авлага нь *төгс дуусаагүй* бөгөөд маш олон хүний хамтын бүтээл юм. Зарим хэсэг нь хуучирч шинэчлэгдэх шаардлагатай байж болзошгүй. Хэрэв та энэ төсөлд хувь нэмрээ оруулж, бидэнд туслахыг хүсвэл FreeBSD баримтжуулах төслийн захидлын жагсаалт (<http://lists.FreeBSD.org/mailman/listinfo/freebsd-doc>) хаяг руу захиа бичнэ үү. Энэ гарын авлагын хамгийн сүүлийн хувилбарыг FreeBSD вэб хуудаснаас (<http://www.FreeBSD.org/>) татаж авч болно. (энэ гарын авлагын өмнөх хувилбаруудыг <http://docs.FreeBSD.org/doc/-с> авах боломжтой). Мөн янз бүрийн шахаж бэлтгэсэн хэлбэрээр FreeBSD FTP серверээс (<ftp://ftp.FreeBSD.org/pub/FreeBSD/doc/>) эсвэл толин тусгал хуудаснаас татаж авагдаж болно. Хэрэв та энэ гарын авлагын хэвлэсэн хуулбарыг авахыг хүсвэл FreeBSD Mall (<http://www.freebsdmail.com/>) хуудсанд зорчино уу. Та мөн гарын авлага дотор хайлт хийх (<http://www.FreeBSD.org/search/index.html>) боломжтой.

Доорх нөхцөл, шаардлагуудыг хангасан нөхцөлд эх код (SGML DocBook) болон 'эмхэтгэгдсэн' хэлбэрүүдийг (SGML, HTML, PDF, PostScript, RTF болон гэх зэрэг) ямарваа өөрчлөлт хийж болон өөрчлөлтгүйгээр хэрэглэх буюу тараах боломжтой:

1. Эх кодыг (SGML DocBook) дээрх эзэмшигчийн эрхийн тэмдэглэл, болон доорх нөхцөл шаардлагууд болон зөрчигдөх тохиолдлуудын хамтаар энэ файлын эхний мөрийг хөндөлгүйгээр түгээнэ.
2. Эмхэтгэгдсэн хэлбэрүүдийн (өөр DTD-үүд болон хувирсан, PDF, PostScript, RTF болон бусад хэлбэршилтүүд рүү хөрвүүлэгдсэн) дахин түгээлтүүд нь дээрх эзэмшигчийн эрхийн тэмдэглэл, доорх нөхцөл шаардлагууд болон түгээлттэй цуг ирсэн баримт ба/эсвэл бусад материалууд дахь зөрчих тохиолдлуудыг үүсгэх ёстой.

**Important:** ЭНЭ БАРИМТ НЬ FREEBSD БАРИМТЖУУЛАХ ТӨСЛӨӨС «БАЙГАА БАЙДЛААРАА» ГЭСЭН НӨХЦӨЛТЭЙГЭЭР ТҮГЭЭГДЭЖ БАЙГАА БӨГӨӨД, ЭНЭ НЬ ХУДАЛДААНЫ, ТОДОРХОЙ НЭГ БОЛОН БУСАД ЗОРИЛГОД НИЙЦЭХ БАТАЛГАА БОЛОХГҮЙ. ЗАЙЛШГҮЙ ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА ЭСВЭЛ /БУРУУ ХЭРЭГЛЭСНЭЭС/ (ХАЙХРАМЖГҮЙ БАЙДАЛ БА БУСАД) ЗЭРЭГ ЭНЭ БАРИМТЫГ ХЭРЭГЛЭСНЭЭС ҮҮДСЭН АЛИВАА ШУУД, ШУУД БУС, ТОХИОЛДЛЫН, ЗОРИУДЫН, ЗАГВАРЧИЛСАН, ЭСВЭЛ ҮР ДАГАВАР БОЛСОН (ЗАХИАЛСАН БҮТЭЭГДЭХҮҮН, ҮЙЛЧИЛГЭЭГ ОРЛУУЛАХ, ХЭРЭГЛЭЭНИЙ ҮЕИЙН ӨГӨГДӨЛ, ХЭРЭГЛЭЭ, АШГИЙН АЛДАГДАЛ, ЭСВЭЛ БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ТАСАЛДУУЛАХ ЗЭРГИЙГ ОРУУЛАХ БӨГӨӨД ҮҮГЭЭР ХЯЗГААРЛАГДАХГҮЙ) ГЭХ МЭТ ЯМАР Ч ТОХИОЛДОЛД, ХЭДИЙ ИЙМ ХОХИРОЛ ГАРЧ БОЛЗОШГҮЙГ АНХААРУУЛСАН БАЙСАН Ч ҮҮНЭЭС ҮҮДСЭН ХОХИРОЛД FREEBSD БАРИМТЖУУЛАХ ТӨСӨЛ НЬ ХУУЛЬ ЁСНЫ ХАРИУЦЛАГА ХҮЛЭЭХГҮЙ.

FreeBSD нь FreeBSD Сангийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

3Com болон HomeConnect нь 3Com Корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

3ware болон Escalade нь 3ware Inc-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

ARM нь ARM Limited-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

Adaptec нь Adaptec, Inc-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

Adobe, Acrobat, Acrobat Reader, болон PostScript нь бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд эсвэл Adobe Systems Incorporated-ийн Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь худалдааны тэмдэгнүүд юм.

Apple, AirPort, FireWire, Mac, Macintosh, Mac OS, Quicktime, болон TrueType нь Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсуудад бүртгэгдсэн Apple Computer, Inc.-ийн худалдааны тэмдэгнүүд юм.

Corel болон WordPerfect нь Канад, Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь Corel корпораци ба/эсвэл түүний салбаруудын бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Sound Blaster нь Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь Creative Technology Ltd.-ийн худалдааны тэмдэгнүүд юм.

CVSup нь Жон Д. Полстрагийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

Heidelberg, Helvetica, Palatino, болон Times Roman нь АНУ болон бусад улсууд дахь Heidelberg Druckmaschinen AG-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд, аль эсвэл худалдааны тэмдэгнүүд юм.

IBM, AIX, EtherJet, Netfinity, OS/2, PowerPC, PS/2, S/390, болон ThinkPad нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь International Business Machines корпорацийн худалдааны тэмдэгнүүд юм.

IEEE, POSIX, болон 802 нь Америкийн Нэгдсэн Улс дахь Institute of Electrical and Electronics Engineers буюу Цахилгаан ба Электроны Инженерүүдийн Сургуулийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Intel, Celeron, EtherExpress, i386, i486, Itanium, Pentium, болон Xeon нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Intel корпораци эсвэл түүний салбаруудын худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Intuit болон Quicken нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Intuit Inc. эсвэл түүний аль нэг салбаруудын бүртгэгдсэн тэмдэгнүүд ба/эсвэл бүртгэгдсэн үйлчилгээний тэмдэгнүүд юм.

Линукс нь Линус Торвалдсын бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

LSI Logic, AcceleRAID, eXtremeRAID, MegaRAID болон Mylex нь LSI Logic Corp-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

M-Systems болон DiskOnChip нь M-Systems Flash Disk Pioneers, Ltd-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Macromedia, Flash, болон Shockwave Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь Macromedia Inc-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Microsoft, IntelliMouse, MS-DOS, Outlook, Windows, Windows Media болон Windows NT нь Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь Microsoft корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд эсвэл худалдааны тэмдэгнүүд юм.

Netscape болон Netscape Navigator нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Netscape Communications корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

GateD болон NextHop нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь NextHop-ийн бүртгэгдсэн эсвэл бүртгэгдээгүй худалдааны тэмдэгнүүд юм.

Motif, OSF/1, болон UNIX нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь The Open Group-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд бөгөөд IT DialTone ба The Open Group нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь The Open Group-ийн худалдааны тэмдэгнүүд юм.

Oracle нь Oracle корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

PowerQuest болон PartitionMagic нь Америкийн Нэгдсэн Улс ба/эсвэл бусад улсууд дахь PowerQuest корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

RealNetworks, RealPlayer, болон RealAudio нь RealNetworks, Inc.-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Red Hat, RPM, нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Red Hat, Inc-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

SAP, R/3, болон mySAP нь Герман болон дэлхий дахины бусад улсууд дахь SAP AG-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Sun, Sun Microsystems, Java, Java Virtual Machine, JavaServer Pages, JDK, JRE, JSP, JVM, Netra, Solaris, StarOffice, Sun Blade, Sun Enterprise, Sun Fire, SunOS, Ultra болон VirtualBox нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Sun Microsystems, Inc-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Symantec болон Ghost нь Америкийн Нэгдсэн Улс болон бусад улсууд дахь Symantec корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

MATLAB нь The MathWorks, Inc-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

SpeedTouch нь Thomson-ий худалдааны тэмдэг юм.

U.S. Robotics болон Sportster нь U.S. Robotics корпорацийн бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

VMware нь VMware, Inc-ийн худалдааны тэмдэг юм.

Waterloo Maple болон Maple нь Waterloo Maple Inc-ийн худалдааны тэмдэгнүүд эсвэл бүртгэгдсэн худалдааны тэмдэгнүүд юм.

Mathematica нь Wolfram Research, Inc-ийн бүртгэгдсэн худалдааны тэмдэг юм.

XFree86 нь XFree86 Project, Inc-ийн худалдааны тэмдэг юм.

Ogg Vorbis болон Xiph.Org нь Xiph.Org-ийн худалдааны тэмдэгнүүд юм.

Үйлдвэрлэгчид болон худалдаалагчдын өөрийнхөө бүтээгдэхүүнүүдээ ашигладаг тэмдэгнүүдийн олонхи нь худалдааны тэмдэг гэж хэлэгддэг. Тийм худалдааны тэмдэгнүүд энэ баримтад гарч байх үед, FreeBSD төсөлд худалдааны тэмдэг мэдэгдэж байвал тэмдэгнүүд дээр “TM” эсвэл “®” тэмдэгт нэмэгддэг.



# Table of Contents

Өмнөх үг .....	xiv
I. Эхлэл .....	xxii
1 Танилцуулга .....	1
1.1 Ерөнхий агуулга.....	1
1.2 FreeBSD-д тавтай морилно уу!.....	1
1.3 FreeBSD Төслийн тухай .....	4
2 FreeBSD суулгах нь.....	10
2.1 Ерөнхий агуулга.....	10
2.2 Системд тавигдах төхөөрөмжийн шаардлага.....	10
2.3 Суулгацын өмнө .....	12
2.4 Суулгацыг эхлүүлэх.....	18
2.5 Sysinstall-н танилцуулга .....	25
2.6 Дискний зайг зохицуулах.....	29
2.7 Юу суулгахаа сонгох.....	42
2.8 Суулгацын төхөөрөмжөө сонгох.....	45
2.9 Суулгацыг баталж гүйцээх.....	47
2.10 Суулгацын дараах тохиргоо .....	48
2.11 Хүндрэл тулгарвал.....	78
2.12 Суулгацын нэмэлт гарын авлага .....	81
2.13 Өөртөө зориулж тусгай суулгацын төхөөрөмж бэлдэх нь .....	83
3 Юниксийн үндэс .....	89
3.1 Ерөнхий агуулга.....	89
3.2 Виртуал консол болон терминал .....	89
3.3 Зөвшөөрлүүд.....	92
3.4 Сангийн бүтэц.....	97
3.5 Диск зохион байгуулалт .....	100
3.6 Файл системийг холбох болон салгах .....	106
3.7 Процесс буюу програмын явц.....	109
3.8 Далд чөтгөр буюу дэмонууд, дохионууд, мөн процессуудыг зогсоох нь .....	111
3.9 Shell буюу бүрхүүл.....	113
3.10 Текст засварлагчид .....	115
3.11 Төхөөрөмж ба төхөөрөмжийн цэгүүд.....	116
3.12 Хоёртын хэлбэрүүд.....	116
3.13 Нэмэлт мэдээлэл олж авах нь .....	118
4 Програм суулгах: Багцууд болон портууд.....	121
4.1 Ерөнхий агуулга.....	121
4.2 Програм суулгацын ерөнхий ойлголт .....	121
4.3 Програмаа олох нь .....	123
4.4 Багцалсан системийг хэрэглэх нь .....	124
4.5 Портын цуглуулгыг хэрэглэх нь.....	127
4.6 Порт суулгасны дараах үйлдлүүд .....	137
4.7 Эвдрэлтэй портыг засах нь .....	138
5 X Цонхот систем .....	139
5.1 Ерөнхий агуулга.....	139
5.2 X-г таньж мэдэх .....	139

5.3 X11-г суулгах нь .....	142
5.4 X11-н тохируулга .....	143
5.5 X11 дээр үсгийн маяг хэрэглэх нь .....	148
5.6 X Display Manager буюу харуулалт зохицуулагч.....	152
5.7 Дэлгэцийн орчин .....	155
<b>II. Нийтлэг асуудлууд .....</b>	<b>160</b>
6 Ширээний програмууд .....	161
6.1 Ерөнхий агуулга.....	161
6.2 Хөтчүүд.....	161
6.3 Бүтээмж.....	165
6.4 Бичиг баримт үзүүлэгчид .....	168
6.5 Санхүү .....	169
6.6 Дүгнэлт .....	171
7 Мультимедиа .....	173
7.1 Ерөнхий агуулга.....	173
7.2 Дууны картыг тохируулах.....	174
7.3 MP3 аудио .....	177
7.4 Видео тоглуулах.....	180
7.5 ТВ картуудыг тохируулах.....	188
7.6 Дүрс скан хийгчид.....	190
8 FreeBSD цөмийг тохируулах нь.....	195
8.1 Ерөнхий агуулга.....	195
8.2 Яагаад өөрчлөн тохируулсан цөм бүтээх хэрэгтэй вэ? .....	195
8.3 Системийн тоног төхөөрөмж хайж олох нь .....	196
8.4 Цөмийн драйверууд, дэд системүүд, болон модулиуд.....	197
8.5 Өөрчлөн тохируулсан цөмийг бүтээх ба суулгах нь .....	197
8.6 Тохиргооны файл .....	200
8.7 Хэрэв ямар нэг юм буруутвал .....	214
9 Хэвлэлт .....	216
9.1 Ерөнхий агуулга.....	216
9.2 Танилцуулга .....	216
9.3 Үндсэн тохируулга .....	217
9.4 Хэвлэгчийн илүү нарийн тохиргоо.....	231
9.5 Хэвлэгчдийг ашиглах нь .....	261
9.6 Хэвлэгчийн стандарт түр хадгалагчидтай ижил хадгалагчид .....	269
9.7 Алдааг олж засварлах .....	270
10 Линуксийн Хоёртын Нийлэмж.....	274
10.1 Ерөнхий агуулга.....	274
10.2 Суулгалт .....	274
10.3 Mathematica® суулгах нь .....	278
10.4 Maple™ суулгах нь .....	280
10.5 MATLAB® суулгах нь .....	282
10.6 Oracle® суулгах нь .....	285
10.7 SAP® R/3® суулгах нь.....	288
10.8 Нэмэлт сэдвүүд.....	310

<b>III. Системийн Удирдлага .....</b>	<b>313</b>
11 Тохиргоо ба Тааруулалт .....	314
11.1 Ерөнхий агуулга.....	314
11.2 Эхний Тохиргоо .....	314
11.3 Гол Тохиргоо .....	316
11.4 Програмын Тохиргоо .....	316
11.5 Үйлчилгээнүүдийг эхлүүлэх нь .....	317
11.6 cron хэрэгслийг тохируулах нь .....	318
11.7 FreeBSD дээр rc ашиглах нь.....	321
11.8 Сүлжээний интерфэйс картууд суулгах нь .....	322
11.9 Виртуал Хостууд .....	328
11.10 Тохиргооны Файлууд.....	329
11.11 sysctl ашиглан тааруулах нь.....	333
11.12 Дискнүүдийг тааруулах нь .....	334
11.13 Цөмийн хязгаарууд тохируулах нь .....	338
11.14 Swap зай нэмэх нь.....	342
11.15 Тэжээл болон Эх үүсвэрийн Удирдлага.....	343
11.16 FreeBSD-ийн ACPI-г ашиглах нь ба дибаг хийх нь .....	344
12 FreeBSD-ийн Ачаалах процесс .....	352
12.1 Ерөнхий агуулга.....	352
12.2 Ачаалалтын асуудал.....	352
12.3 Ачаалагч Менежер болон Ачаалалтын шатууд .....	353
12.4 Ачаалах үе дэх цөмийн харилцан үйлдэл .....	359
12.5 Төхөөрөмжийн Сануулгууд.....	360
12.6 Init: Процесс хяналтын эхлүүлэлт .....	361
12.7 Унтраах дараалал.....	362
13 Хэрэглэгчид ба үндсэн бүртгэл зохицуулалт .....	363
13.1 Ерөнхий агуулга.....	363
13.2 Танилцуулга .....	363
13.3 Супер хэрэглэгчийн бүртгэл.....	365
13.4 Систем бүртгэл.....	365
13.5 Энгийн хэрэглэгчийн бүртгэл .....	365
13.6 Бүртгэлд өөрчлөлт хийх.....	366
13.7 Хэрэглэгчдэд хязгаарлалт хийх .....	370
13.8 Бүлэг.....	372
14 Аюулгүй байдал.....	375
14.1 Ерөнхий агуулга.....	375
14.2 Танилцуулга .....	375
14.3 FreeBSD-н аюулгүй байдлыг хангах нь.....	377
14.4 DES, MD5, болон Crypt.....	386
14.5 Нэг удаагийн нууц үгүүд.....	387
14.6 TCP Гүйцэтгэлийг хялбаршуулагчид .....	390
14.7 <b>KerberosIV</b> .....	393
14.8 <b>Kerberos5</b> .....	400
14.9 OpenSSL.....	409
14.10 IPsec дээгүүр VPN хийх .....	412
14.11 OpenSSH .....	418
14.12 Файлын системийн хандалт хянах жагсаалтууд.....	424

14.13 Гуравдагч талын аюулгүй байдлын асуудлуудыг монитор хийх нь .....	426
14.14 FreeBSD-ийн аюулгүй байдлын зөвлөгөөнүүд.....	427
14.15 Процессийн бүртгэл хөтлөх .....	429
15 Jails буюу Шоронгууд .....	431
15.1 Ерөнхий агуулга.....	431
15.2 Шоронгуудтай холбоотой ойлголтууд .....	431
15.3 Танилцуулга .....	432
15.4 Шоронг үүсгэж хянах нь.....	433
15.5 Нарийн тааруулалт болон удирдлага .....	435
15.6 Шоронгийн хэрэглээ .....	436
16 Mandatory Access Control буюу Албадмал Хандалтын хяналт.....	443
16.1 Ерөнхий агуулга.....	443
16.2 Энэ бүлэг дэх түлхүүр ухагдахуунууд .....	444
16.3 MAC-ийн тайлбар.....	445
16.4 MAC хаяг/шошгонуудыг ойлгох нь .....	447
16.5 Аюулгүй байдлын тохиргоог төлөвлөх нь .....	452
16.6 Модулийн тохиргоо .....	452
16.7 MAC seeotheruids модуль .....	453
16.8 MAC bsdextended модуль .....	453
16.9 MAC ifoff модуль .....	454
16.10 MAC portacl модуль .....	455
16.11 MAC хуваалтын модуль.....	456
16.12 MAC олон түвшинт аюулгүй байдлын модуль.....	457
16.13 MAC Biba модуль.....	459
16.14 MAC LOMAC модуль.....	461
16.15 MAC Шорон дахь Nagios.....	462
16.16 Хэрэглэгчийг түгжих .....	465
16.17 MAC Тогтолцооны алдааг олж засварлах .....	466
17 Аюулгүй байдлын үйл явцад аудит хийх нь .....	469
17.1 Ерөнхий агуулга.....	469
17.2 Энэ бүлгийн түлхүүр ухагдахуунууд.....	469
17.3 Аудит хийх дэмжлэг суулгах нь .....	470
17.4 Аудитийн тохиргоо.....	471
17.5 Аудит дэд системийг удирдах нь.....	474
18 Хадгалалт .....	478
18.1 Ерөнхий агуулга.....	478
18.2 Төхөөрөмжийн нэрс .....	478
18.3 Диск нэмэх .....	479
18.4 RAID.....	481
18.5 USB хадгалалтын төхөөрөмжүүд.....	486
18.6 Оптик зөөвөрлөгчийг (CD-үүд) үүсгэж ашиглах нь .....	488
18.7 Оптик зөөвөрлөгчийг (DVD-үүд) үүсгэж ашиглах нь .....	494
18.8 Уян дискнүүдийг үүсгэж ашиглах нь .....	500
18.9 Өгөгдлийн соронзон хальснууд үүсгэж ашиглах нь .....	501
18.10 Уян диск уруу нөөцлөх .....	504
18.11 Нөөцлөх стратегиуд.....	506
18.12 Нөөцлөлтийн үндсүүд .....	506
18.13 Сүлжээ, санах ой болон файл дээр тулгуурласан файлын системүүд.....	514

18.14	Файлын системийн хормын хувилбарууд.....	516
18.15	Файлын системийн ноогдлууд.....	517
18.16	Дискний хуваалтуудыг шифрлэх нь.....	521
18.17	Swap зайг шифрлэх.....	527
19	GEOM: Модульчлагдсан Диск Хувиргах Тогтолцоо .....	530
19.1	Ерөнхий агуулга.....	530
19.2	GEOM-ийн Танилцуулга.....	530
19.3	RAID0 - Судал үүсгэх.....	530
19.4	RAID1 - Толин тусгал үүсгэх.....	532
19.5	GEOM Хаалга Сүлжээний Төхөөрөмжүүд.....	535
19.6	Дискний төхөөрөмжүүдийг хаяглах нь.....	536
19.7	GEOM-ийн тусламжтай UFS тэмдэглэл .....	538
20	Файлын системийн дэмжлэг .....	541
20.1	Ерөнхий агуулга.....	541
20.2	Z Файлын Систем (ZFS).....	541
21	Vinum Эзлэхүүн Менежер .....	549
21.1	Ерөнхий агуулга.....	549
21.2	Дискнүүд хэтэрхий жижиг .....	549
21.3	Хандалтын таглалартууд.....	549
21.4	Өгөгдлийн бүрэн бүтэн байдал .....	552
21.5	Vinum объектууд.....	553
21.6	Зарим жишээнүүд.....	555
21.7	Объектийн нэрлэлт .....	561
21.8	Vinum тохируулах нь .....	563
21.9	Root файлын системийн хувьд Vinum-ийг ашиглах нь .....	565
22	Виртуалчлал.....	571
22.1	Ерөнхий агуулга.....	571
22.2	FreeBSD-г зочин OS маягаар ашиглах .....	571
22.3	FreeBSD-г хост буюу эх OS маягаар ашиглах.....	616
23	Локалчлал - I18N/L10N-ийн хэрэглээ болон тохируулга .....	619
23.1	Ерөнхий агуулга.....	619
23.2	Үндсүүд.....	619
23.3	Локалчлалыг ашиглах нь.....	620
23.4	I18N програмуудыг эмхэтгэх.....	626
23.5	FreeBSD-г өөр хэлнүүд уруу локалчлах.....	626
24	FreeBSD-г шинэчилж сайжруулах нь .....	630
24.1	Ерөнхий агуулга.....	630
24.2	FreeBSD-ийн шинэчлэлт.....	630
24.3	Portsnap: Портын цуглуулгыг шинэчлэх хэрэгсэл .....	637
24.4	Баримтын цуглуулгыг шинэчлэх нь .....	638
24.5	Хөгжүүлэлтийн салбарыг дагах нь .....	644
24.6	Өөрийн эхийг хамгийн сүүлийн хэлбэрт аваачих нь .....	648
24.7	“Ертөнц”ийг дахин бүтээх нь .....	649
24.8	Олон машины хувьд дагах нь.....	665
25	DTrace .....	667
25.1	Ерөнхий агуулга.....	667
25.2	Шийдлийн ялгаанууд .....	667
25.3	DTrace дэмжлэгийг идэвхжүүлэх .....	668

25.4 DTrace-г ашиглах.....	669
25.5 D хэл .....	671
<b>IV. Сүлжээний Холболт.....</b>	<b>672</b>
26 Цуваа холбоонууд.....	673
26.1 Ерөнхий агуулга.....	673
26.2 Танилцуулга .....	673
26.3 Терминалууд.....	678
26.4 Dial-in буюу гаднаас залгах үйлчилгээ .....	683
26.5 Dial-out буюу гадагш залгах үйлчилгээ .....	691
26.6 Цуваа консольтыг тохируулах нь.....	695
27 PPP болон SLIP.....	704
27.1 Ерөнхий агуулга.....	704
27.2 Хэрэглэгчийн PPP ашиглах.....	704
27.3 Цөмийн PPP-г ашиглах.....	717
27.4 PPP холболтуудын алдааг олж засварлах.....	724
27.5 Ethernet дээгүүр PPP ашиглах нь (PPPoE).....	728
27.6 ATM дээгүүр PPP (PPPoA) ашиглах.....	730
27.7 SLIP ашиглах.....	733
28 Цахим Шуудан.....	742
28.1 Ерөнхий Агуулга.....	742
28.2 Цахим Захидлыг Хэрэглэх нь .....	742
28.3 <b>sendmail</b> -г Тохируулах нь.....	745
28.4 Өөрийн Захидал Дамжуулах Агентийг Солих нь.....	747
28.5 Гэмтэл саатлыг арилгах нь .....	749
28.6 Дээд түвшний сэдвүүд .....	752
28.7 UUCP-тэй SMTP .....	755
28.8 Зөвхөн илгээхээр тохируулах нь.....	756
28.9 Гадагш залгах холболтоор захидлыг ашиглах нь.....	757
28.10 SMTP нэвтрэлт танилт.....	759
28.11 Хэрэглэгчийн захидал дамжуулагчид .....	760
28.12 fetchmail-г ашиглах нь .....	767
28.13 procmail-г ашиглах нь .....	768
29 Сүлжээний орчны Серверүүд .....	770
29.1 Ерөнхий агуулга.....	770
29.2 <b>inetd</b> “Супер-Сервер”.....	770
29.3 Сүлжээний Файлын Систем (NFS) .....	775
29.4 Сүлжээний Мэдээллийн Систем (NIS/YP).....	781
29.5 Автомат Сүлжээний Тохиргоо (DHCP) .....	797
29.6 Домэйн Нэрийн Систем (DNS).....	802
29.7 Apache HTTP Сервер .....	814
29.8 Файл Дамжуулах Протокол (FTP).....	819
29.9 Microsoft Windows харилцагчдад зориулсан Файл болон Хэвлэх Үйлчилгээ (Samba) ....	821
29.10 NTP-р Цаг Тааруулах нь .....	824
29.11 syslogd ашиглан алсын хост руу бүртгэх нь.....	827
30 Галт хана.....	832
30.1 Танилцуулга .....	832
30.2 Галт ханын тухай ойлголтууд.....	832

30.3 Галт ханын багцууд.....	833
30.4 OpenBSD Пакет шүүгч (PF) ба ALTQ.....	833
30.5 IPFILTER (IPF) Галт хана.....	837
30.6 IPFW.....	856
31 Сүлжээний нэмэлт ойлголтууд.....	875
31.1 Ерөнхий агуулга.....	875
31.2 Гарцууд болон Чиглүүлэлтүүд.....	875
31.3 Утасгүй сүлжээ.....	882
31.4 Bluetooth.....	902
31.5 Гүүр.....	911
31.6 Холбоос нэгтгэлт ба ослыг тойрон гарах (Link Aggregation and Failover).....	917
31.7 Дискгүй ажиллагаа.....	921
31.8 ISDN.....	928
31.9 Network Address Translation буюу Сүлжээний Хаягийн Хөрвүүлэлт.....	932
31.10 Parallel Line IP (PLIP) буюу Зэрэгцээ Шугамын IP.....	936
31.11 IPv6.....	938
31.12 Asynchronous Transfer Mode (ATM) буюу Асинхрон Дамжуулах Горим.....	943
31.13 Common Address Redundancy Protocol (CARP).....	944
<b>V. Хавсралтууд.....</b>	<b>948</b>
A. FreeBSD-г олж авах нь.....	949
A.1 CDROM болон DVD Нийтлэгчид.....	949
A.2 FTP сайтууд.....	951
A.3 BitTorrent.....	962
A.4 Нэргүй CVS.....	962
A.5 CTM-г ашиглах нь.....	965
A.6 CVSup-г ашиглах нь.....	969
A.7 CVS Tags буюу хаягууд.....	992
A.8 AFS сайтууд.....	999
A.9 rsync сайтууд.....	999
B. Ном зүй.....	1001
B.1 FreeBSD-ийн талаар тусгайлан бичсэн ном & сэтгүүлүүд.....	1001
B.2 Хэрэглэгчдийн гарын авлагууд.....	1002
B.3 Администраторууд зориулсан зааврууд.....	1003
B.4 Програм зохиогчдод зориулсан зааврууд.....	1003
B.5 Үйлдлийн системийн дотоод бүрэлдэхүүнүүдийн талаар.....	1004
B.6 Аюулгүй байдлын тухай номнууд.....	1004
B.7 Тоног төхөөрөмжийн тухай номнууд.....	1005
B.8 UNIX-ийн түүх.....	1005
B.9 Сонин, сэтгүүлүүд.....	1006
C. Интернэт дэх эх үүсвэрүүд.....	1007
C.1 Захидлын жагсаалтууд.....	1007
C.2 Usenet Newsgroups буюу мэдээний бүлгүүд.....	1028
C.3 Word Wide Web серверүүд.....	1029
C.4 Цахим захидлын хаягууд.....	1037
D. PGP түлхүүрүүд.....	1038
D.1 Албан хаагчид.....	1038
D.2 Гол багийн гишүүд.....	1038

D.3 Хөгжүүлэгчид.....	1040
<b>FreeBSD Нэр томъёо .....</b>	<b>1101</b>
<b>Colophon.....</b>	<b>1126</b>



# List of Tables

2-1. Төхөөрөмжийн бүртгэлийн жишээ .....	12
2-2. Эхний дискний хуваалт .....	36
2-3. Бусад дискэн дээрх дискний хуваалт .....	37
2-4. FreeBSD 6.x ба 7.x ISO буулгац дүрсний нэр болон агуулга .....	83
3-1. Диск төхөөрөмжийн нэрнүүд .....	105
18-1. Физик диск нэрлэх заншил .....	478
21-1. Vinum Plex зохион байгуулалтууд .....	554
26-1. DB-25-аас DB-25 Null-Модем кабель .....	674
26-2. DB-9-өөс DB-9 Null-Модем кабель .....	674
26-3. DB-9-өөс DB-25 Null-Модем кабель .....	675
26-4. Дохионы нэрс .....	684
31-1. Сүлжээнд зориулж зэрэгцээ кабель хийх нь .....	936
31-2. Нөөц IPv6 хаягууд .....	939

# Өмнөх үг

## Энэ номын зориулалт

FreeBSD-ийн шинэ хэрэглэгч нь энэ номын эхний хэсэг хэрэглэгчид FreeBSD-ийн суулгалтын процесс дундуур хөтөлж UNIX®-ийн угт байдаг ойлголтууд болон ёс заншлыг аажим танилцуулдаг болохыг олж мэдэх болно. Энэ хэсэг дээр ажиллах нь шинээр олж мэдэх хүсэл эрмэлзлээс арай илүү хүсэл болон танилцуулсан шинэ ойлголтуудыг хүлээн авах чадварыг шаарддаг.

Гарын авлагын хоёр дахь хамаагүй том хэсэг хүрэх үед FreeBSD системийн администраторуудын сонирхлыг татах бүх сэдвүүдийг хамарсан нэвтэрхий лавлахыг та олох болно. Эдгээр бүлгүүдийн зарим нь таныг урьдчилан уншихыг зөвлөж болох бөгөөд энэ нь бүлэг бүрийн эхэнд ерөнхий агуулгад тэмдэглэгдсэн байдаг.

Мэдээллийн нэмэлт эхүүдийн жагсаалтыг **Appendix B** хэсгээс үзнэ үү.

## Гурав дахь хэвлэлээс хойшх өөрчлөлтүүд

Гарын авлагын одоогийн хувилбар нь сүүлийн 10 жилийн хугацааны туршид олон зуун хувь нэмэр болгон оруулагчийн оруулсан хүчин чармайлтын үр дүн юм. Дараах нь 2004 онд хэвлэгдсэн гурав дахь хэвлэлийн хоёр ботиос хойш орсон мэдэгдэхүйц өөрчлөлтүүд юм:

- **Chapter 25** буюу DTrace нь хүчирхэг DTrace үйл ажиллагааны шинжилгээ хийх хэрэгслийн талаарх мэдээллийн хамтаар нэмэгдсэн.
- **Chapter 20** буюу Файлын системийн дэмжлэг нь Sun™-ий ZFS зэрэг FreeBSD дээрх эх биш файлын системүүдийн талаарх мэдээллийн хамтаар нэмэгдсэн.
- **Chapter 17** Аюулгүй байдлын үйл явцад аудит хийх бүлэг FreeBSD дэх аудит хийх шинэ боломж болон түүний хэрэглээг тайлбарсан мэдээллийн хамтаар нэмэгдсэн.
- **Chapter 22** буюу Виртуалчлал нь виртуалчлалын програм хангамж дээр FreeBSD-ийг суулгах мэдээллийн хамтаар нэмэгдсэн.

## Хоёр дахь хэвлэлээс (2004) хойшх өөрчлөлтүүд

Энэ гурав дахь хэвлэлт нь FreeBSD баримтжуулах төслийн гишүүдийн хоёр жил илүүтэй хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын оргил юм. Хэвлэсэн хувилбарын хэмжээ ихэссэн учир хоёр тусдаа боть болгох шаардлагатай болсон. Энэ шинэ хэвлэлтэд орсон гол өөрчлөлтүүдийг доор дурдав:

- **Chapter 11** Тохиргоо ба тааруулалт нь ACPI тэжээл болон эх үүсвэрийн удирдлага, cron системийн хэрэгсэл болон цөмийн илүү олон тааруулах тохируулгуудын тухай шинэ мэдээллээр өргөжсөн.
- **Chapter 14** Аюулгүй байдал нь виртуал хувийн сүлжээнүүд (VPN-үүд), файлын системийн хандалт хяналтын жагсаалт (ACL-үүд) болон аюулгүй байдлын зөвлөгөөнүүдийн тухай шинэ мэдээллээр өргөжсөн.
- **Chapter 16** Mandatory Access Control буюу Албадмал Хандалтын хяналт нь энэ хэвлэл дэх шинэ бүлэг юм. Энэ нь MAC гэж юу болох, FreeBSD системийг аюулгүй болгоход энэ аргыг хэрхэн ашиглах талаар тайлбарладаг.

- **Chapter 18** Хадгалалт нь USB хадгалалтын төхөөрөмжүүд, файлын системийн хормын хувилбарууд, файлын системийн хувь/ноогдлууд, файл болон сүлжээн дээр тулгуурласан файлын системүүд болон шифрлэгдсэн дискний хуваалтуудын тухай шинэ мэдээллээр өргөжсөн.
- **Chapter 21** Vinum нь энэ хэвлэл дэх шинэ бүлэг юм. Энэ нь Vinum-ийг хэрхэн ашиглах, төхөөрөмжийн хувьд хамааралгүй логик дискнүүдийн боломжийг хангадаг логик эзлэхүүн менежер болон програм хангамжийн RAID-0, RAID-1 болон RAID-5-г тайлбарладаг.
- Алдааг олж засварлах хэсэг **Chapter 27** PPP ба SLIP-д нэмэгдсэн.
- **Chapter 28** Цахим шуудан нь өөр тээвэрлэх агентуудыг ашиглах, SMTP нэвтрэлт танилт, UUCP, fetchmail, procmail, болон бусад дэвшилтэт сэдвүүдийн тухай шинэ мэдээллээр өргөжсөн.
- **Chapter 29** Сүлжээний серверүүд нь энэ хэвлэлд бүгд шинээр орсон. Энэ бүлэг нь **Apache HTTP Server**, **ftpd**-г тохируулах болон Microsoft® Windows® клиентүүдийн хувьд **Samba** серверийг тохируулах тухай мэдээллийг агуулдаг. **Chapter 31** Сүлжээний нэмэлт ойлголтууд дахь зарим хэсгүүд нь танилцуулгыг сайжруулахын тулд ийшээгээ зөөгдсөн.
- **Chapter 31** Сүлжээний нэмэлт ойлголтууд нь FreeBSD дээр Bluetooth® төхөөрөмжүүдийг ашиглах, утасгүй сүлжээнүүд болон Асинхрон Дамжуулах Горим (ATM) сүлжээг тохируулах тухай шинэ мэдээллээр өргөжсөн.
- Номонд ашиглагдсан техникийн ухагдахуунуудын тодорхойлолтуудад зориулагдсан төв байршлыг бий болгон нэр томъёо хэсэг нэмэгдсэн.
- Номонд байгаа хүснэгтүүд болон зургуудад хэд хэдэн гоо зүйн сайжруулалтууд хийгдсэн.

## Эхний хэвлэлээс (2001) хойшх өөрчлөлтүүд

Хоёр дахь хэвлэлт нь FreeBSD баримтжуулах төслийн гишүүдийн хоёр жил илүүтэй хугацаанд хийж гүйцэтгэсэн ажлын оргил юм. Энэ хэвлэлтэд орсон гол өөрчлөлтүүдийг доор дурдав:

- Бүрэн хэмжээний үгсийн жагсаалт нэмэгдсэн.
- Бүх ASCII зурагнууд график диаграмуудаар солигдсон.
- Бүлэг ямар мэдээлэл агуулсан болох, уншигч юу мэдэхийг харуулсан товч мэдээллийг өгөхийн тулд бүлэг болгонд стандарт ерөнхий агуулга нэмэгдсэн.
- Агуулга логикийн хувьд гурван хэсэгт дахин зохион байгуулагдсан: “Эхлэл”, “Системийн удирдлага”, болон “Хавсралтууд”.
- **Chapter 2** (“FreeBSD-г суулгах нь”) шинэ хэрэглэгчдэд текстийг хялбар авах боломжийг бүрдүүлэх олон дэлгэцийн агшнуудтайгаар бүрэн хэмжээгээр дахин бичигдсэн.
- **Chapter 3** (“UNIX-ийн үндэс”) процессууд, дэмонууд болон дохионуудын тухай нэмэлт мэдээллийг агуулж өргөжсөн.
- **Chapter 4** (“Програм суулгах”) хоёртын багцын удирдлагын тухай нэмэлт мэдээллийг агуулж өргөжсөн.
- **Chapter 5** (“X Цонхот систем”) нь орчин үеийн ширээний технологиуд болох **KDE** болон **GNOME**-г XFree86™ 4.X дээр ашиглах тал дээр онцлон анхаарч бүрэн хэмжээгээр дахин бичигдсэн.
- **Chapter 12** (“FreeBSD-ийн ачаалах процесс”) нь өргөжсөн.

- Chapter 18 (“Хадгалалт”) өмнө нь тусдаа байсан “Дискнүүд” болон “Нөөцлөлтүүд” гэсэн хоёр бүлгээс бичигдсэн. Сэдвүүдийг нэг бүлэг болгон танилцуулах нь хялбар болохыг бид мэдэрсэн. RAID-ийн тухай хэсэг (тоног төхөөрөмж болон програм хангамж) бас нэмэгдсэн.
- Chapter 26 (“Цуваа холболтууд”) FreeBSD 4.X/5.X-ийн хувьд бүрэн хэмжээгээр дахин зохион байгуулагдаж шинэчлэгдсэн.
- Chapter 27 (“PPP ба SLIP”) нэлээн хэмжээгээр шинэчлэгдсэн.
- Олон хэсэг Chapter 31-д (“Сүлжээний тухай нэмэлт ойлголтууд”) нэмэгдсэн.
- Chapter 28 (“Цахим шуудан”) **sendmail**-г тохируулах тухай илүү мэдээллийг агуулж өргөжсөн.
- Chapter 10 (“Linux®-ийн хоёртын нийлэмж”) **Oracle®** болон **SAP® R/3®**-г суулгах тухай мэдээллийг агуулж өргөжсөн.
- Дараах шинэ сэдвүүдийг энэ хоёр дахь хэвлэлд хэлэлцсэн:
  - Тохиргоо ба тааруулалт (Chapter 11).
  - Мультимедиа (Chapter 7)

## Энэ номын зохион байгуулалт

Энэ ном нь таван логикийн хувьд тусдаа хэсгүүдэд хуваагдана. Эхний хэсэг *Эхлэл* нь FreeBSD-ийн суулгалт болон үндсэн хэрэглээг тайлбарлах болно. Эдгээр бүлгүүдийг дарааллаар нь магадгүй мэддэг сэдвүүдийг тайлбарлах бүлгүүдийг орхин уншина гэдэгт уншигч авхай нарт итгэдэг. Хоёр дахь хэсэг *Нийтлэг асуудлууд* нь FreeBSD-ийн зарим нэг байнга ашиглагддаг боломжуудыг тайлбарладаг. Энэ хэсэг болон дараачийн хэсгүүдийг дараалал хамаарахгүйгээр уншиж болно. Бүлэг бүр нь бүлэг юу тайлбарладаг болон уншигч юуг аль хэдийн мэдсэн байх ёстойг тайлбарласан хураангуй агуулгаас эхэлдэг. Энэ нь уншигчид өөрийн сонирхсон бүлгээ олоход туслах зорилготой юм. Гурав дахь хэсэг *Системийн удирдлага* нь удирдлагын сэдвүүдийг хөнддөг. Дөрөв дэх хэсэг *Сүлжээний холболт* нь сүлжээ болон серверийн сэдвүүдийг хамардаг. Тав дахь хэсэг нь лавлагаа мэдээллийн тухай хавсралтуудыг агуулдаг.

### Chapter 1 Танилцуулга

FreeBSD-г шинэ хэрэглэгчид танилцуулна. Энэ нь FreeBSD төслийн түүх, түүний зорилгууд болон хөгжүүлэлтийн загварыг тайлбарладаг.

### Chapter 2 Суулгалт

Хэрэглэгчийг суулгалтын процесс дундуур хөтөлнө. Цуваа консолоор суулгах зэрэг илүү нарийн суулгалтын сэдвүүдийг бас тайлбарлана.

### Chapter 3, UNIX-ийн үндэс

FreeBSD үйлдлийн системийн үндсэн тушаалууд болон ажиллагааг тайлбарладаг. Хэрэв та Linux эсвэл UNIX-ийн өөр төрлийг мэддэг бол та энэ бүлгийг алгасаж болох юм.

### Chapter 4 Програм суулгах нь

FreeBSD-ийн шинэ санаачлага “портын цуглуулга” болон стандарт хоёртын багцуудын тусламжтай гуравдагч програм хангамжуудын суулгалтыг тайлбарладаг.

*Chapter 5 X Цонхот систем*

X Цонхот системийг ерөнхийд нь болон FreeBSD-г ялангуяа X11 дээр ашиглах талаар тайлбарлах болно. **KDE** болон **GNOME** зэрэг ширээний түгээмэл орчнуудыг бас тайлбарладаг.

*Chapter 6 Ширээний програмууд*

Вэб хөтчүүд болон бүтээмжийн цуглуулгууд зэрэг зарим нэгэн ширээний програмуудыг дурдах бөгөөд тэдгээрийг FreeBSD дээр хэрхэн суулгах талаар тайлбарлах болно.

*Chapter 7 Мультимедиа*

Дуу болон дүрс тоглуулалтын дэмжлэгийг өөрийн систем дээр хэрхэн тохируулахыг үзүүлнэ. Бас зарим жишээ аудио болон видео програмуудыг тайлбарладаг.

*Chapter 8 FreeBSD цөмийг тохируулах нь*

Танд яагаад шинэ цөм хэрэгтэй болж болохыг тайлбарлаж цөмийг тохируулах, бүтээх болон суулгах тухай дэлгэрэнгүй заавруудыг өгнө.

*Chapter 9 Хэвлэлт*

Сурталчилгаа хуудаснууд, хэвлэгчийн бүртгэл болон эхний тохиргоо зэрэг мэдээллийг оруулаад хэвлэгчдийг FreeBSD дээр удирдах талаар тайлбарладаг.

*Chapter 10, Linux-ийн хоёртын нийлэмж*

FreeBSD-ийн Linux-тэй нийцтэй боломжуудыг тайлбарладаг. Бас **Oracle**, **SAP R/3**, болон **Mathematica®** зэрэг Linux-ийн олон түгээмэл програмуудыг суулгах дэлгэрэнгүй заавруудыг өгдөг.

*Chapter 11 Тохиргоо ба тааруулалт*

FreeBSD-г хамгийн оновчтой ажиллагаанд зориулж тааруулахад туслах системийн администраторуудад зориулсан параметруудийг тайлбарладаг. Бас FreeBSD-д ашиглагдах төрөл бүрийн тохиргооны файлуудыг тайлбарлаж тэдгээрийг хаанаас олохыг хэлж өгдөг.

*Chapter 12 Эхлүүлэх процесс*

FreeBSD-ийн эхлүүлэх процессийг тайлбарлаж тохиргооны сонголтуудын тусламжтай энэ процессийг хэрхэн хянах талаар дурддаг.

*Chapter 13 Хэрэглэгчид ба үндсэн бүртгэл зохицуулалт*

Хэрэглэгчийн бүртгэлүүдийг үүсгэх болон удирдахыг тайлбарладаг. Бас хэрэглэгчид дээр эх үүсвэрийн хязгаарлалтуудыг тохируулах болон бусад бүртгэл удирдах ажлуудын талаар тайлбарладаг.

*Chapter 14 Аюулгүй байдал*

Kerberos, IPsec, болон OpenSSH зэргийг оролцуулаад таны FreeBSD системийг аюулгүй болгоход туслах олон хэрэгслүүдийг тайлбарладаг.

*Chapter 15 Jails буюу Шоронгууд*

Шоронгийн тогтолцоо болон FreeBSD-ийн уламжлалт chroot дэмжлэг дээр нэмэгдсэн шоронгийн сайжруулалтуудыг тайлбарладаг.

*Chapter 16 Mandatory Access Control буюу Албадмал Хандалтын хяналт*

Mandatory Access Control (MAC) буюу Албадмал Хандалтын хяналт гэж юу болохыг тайлбарладаг бөгөөд FreeBSD системийг аюулгүй болгоход энэ арга замыг хэрхэн ашиглах талаар хэлэлцдэг.

*Chapter 17 Аюулгүй байдлын үйл явцад аудит хийх нь*

FreeBSD-ийн үйл явцын аудит гэж юу болох, түүнийг хэрхэн суулгах, тохируулах болон аудит мөрнүүд хэрхэн шалгагдаж эсвэл монитор хийгддэг талаар тайлбарладаг.

*Chapter 18 Хадгалалт*

Хадгалалтын зөөвөрлөгч болон файлын системүүдийг FreeBSD-ээр хэрхэн удирдахыг тайлбарладаг. Үүнд физик дискнүүд, RAID массивууд, оптик болон соронзон хальсан зөөвөрлөгч, санах ой дээр тулгуурласан дискнүүд болон сүлжээний файлын системүүд ордог.

*Chapter 19 GEOM*

FreeBSD дээрх GEOM тогтолцоо гэж юу болох, төрөл бүрийн дэмжигдсэн RAID түвшнүүдийг хэрхэн тохируулах талаар тайлбарладаг.

*Chapter 20 Файлын системийн дэмлэг*

Sun-ий Z файлын систем зэрэг FreeBSD дээрх төрөлхийн биш файлын системүүдийн дэмжлэгийн талаар тайлбарладаг.

*Chapter 21 Vinum*

Төхөөрөмжөөс хамааралгүй логик дискнүүд болон програм хангамжийн RAID-0, RAID-1 болон RAID-5 зэргийн боломжийг олгодог логик эзлэхүүн менежер Vinum-ийг хэрхэн ашиглах талаар тайлбарладаг.

*Chapter 22 Виртуалчлал*

Виртуалчлалын системүүд юу санал болгодог болон тэдгээрийг FreeBSD-тэй хэрхэн ашиглаж болохыг тайлбарладаг.

*Chapter 23 Локалчлал*

Англи хэлнээс бусад хэлнүүд дээр FreeBSD-г хэрхэн ашиглах талаар тайлбарладаг. Систем болон програмын түвшингийн локалчлалыг дурддаг.

*Chapter 24 FreeBSD-г шинэчилж сайжруулах нь*

FreeBSD-STABLE, FreeBSD-CURRENT болон FreeBSD-ийн хувилбаруудын ялгаануудыг тайлбарладаг. Хөгжүүлэлтийн системийг дагахад ямар хэрэглэгчдэд ашигтайг тайлбарлаж тэр процессийг дурддаг. Хэрэглэгчид өөрсдийн системийг аюулгүй байдлын хамгийн сүүлийн үеийн хувилбар руу шинэчлэх аргуудыг тайлбарладаг.

*Chapter 25 DTrace*

FreeBSD дээр Sun-ий DTrace хэрэгслийг хэрхэн тохируулж хэрэглэх талаар тайлбарладаг. Динамикаар дагаж мөрдөх нь ажиллаж байх явцад системийн шинжилгээ хийж гүйцэтгэн үйл ажиллагааны асуудлуудыг олоход тусалж чадна.

*Chapter 26 Цуваа холбоонууд*

Терминалууд болон модемуудыг өөрийн FreeBSD системд гадагш залгах болон дуудлага хүлээн авах холболтуудад зориулж хэрхэн холбох талаар тайлбарладаг.

*Chapter 27 PPP ба SLIP*

FreeBSD дээр PPP, SLIP, эсвэл Ethernet дээгүүрх PPP-г хэрхэн ашиглаж алсын системд холбогдохыг тайлбарладаг.

*Chapter 28 Цахим шуудан*

Цахим захидлын серверийн бүрэлдэхүүн хэсгүүдийг тайлбарлаж хамгийн түгээмэл захидлын програм хангамж болох **sendmail**-д зориулсан хялбар тохиргооны сэдвүүдийн талаар өгүүлдэг.

*Chapter 29 Сүлжээний серверүүд*

Таны FreeBSD машиныг сүлжээний файлын систем сервер, домэйн нэрний сервер, сүлжээний мэдээллийн систем сервер эсвэл цаг тааруулах сервер болгон хэрхэн тохируулах тухай дэлгэрэнгүй зааврууд болон жишээ тохиргооны файлуудыг дурддаг.

*Chapter 30 Галт хананууд*

Програм хангамж дээр суурилсан галт ханануудын цаадах философиог тайлбарлаж FreeBSD-д зориулсан төрөл бүрийн галт ханануудын тохиргооны тухай дэлгэрэнгүй мэдээллийг өгүүлдэг.

*Chapter 31 Сүлжээний нэмэлт ойлголтууд*

Өөрийн LAN доторх бусад компьютеруудтай Интернэтийн холболтоо хуваалцах, чиглүүлэлтийн дэвшилтэт сэдвүүд, утасгүй сүлжээ, Bluetooth, ATM, IPv6 зэрэг зүйлсийг оролцуулаад сүлжээний олон сэдвүүдийг тайлбарладаг.

*Appendix A FreeBSD-г олж авах нь*

FreeBSD зөөвөрлөгчийг CDROM эсвэл DVD дээр олж авахад зориулагдсан төрөл бүрийн эхүүд болон FreeBSD-г татан авч суулгах боломжийг танд олгох Интернэт дэх олон сайтуудыг дурддаг.

*Appendix B Ном зүй*

Энэ ном нь маш олон төрөл бүрийн сэдвүүдийг хөнддөг бөгөөд таныг магадгүй илүү дэлгэрэнгүй мэдээлэл авах хүсэлд хөтлөж болох юм. Ном зүй нь энэ номонд ашигласан олон гайхалтай номнуудыг дурдсан байдаг.

*Appendix C Интернэт дэх эх үүсвэрүүд*

FreeBSD-ийн хэрэглэгчдэд зориулсан, асуултууд илгээж FreeBSD-ийн талаар техникийн хэлэлцүүлгүүд өрнүүлж болох олон хэлэлцүүлгүүд байдаг талаар тайлбарладаг.

*Appendix D PGP түлхүүрүүд*

FreeBSD-ийн хэд хэдэн хөгжүүлэгчдийн PGP түлхүүрүүдийг жагсаадаг.

## Энэ номонд ашиглагдсан бичиглэлийн хэлбэрүүд

Текстийг уншихад хялбар, дэс дараалалтай болгохын тулд энэ номонд хэд хэдэн бичиглэлийн хэлбэрүүдийг ашигласан.

## Хэвлэлийн хэлбэрүүд

### *Italic*

*italic* фонт нь файлын нэрс, URL-ууд, онцолсон текст болон техникийн ухагдахуунуудын эхний хэрэглээнд *italic* үсгийн маяг ашиглагдсан.

### Monospace

monospace хийгдсэн үсгийн маяг нь алдааны мэдэгдлүүд, тушаалууд, орчны хувьсагчууд, портуудын нэрс, хостын нэрс, хэрэглэгчдийн нэрс, бүлгийн нэрс, төхөөрөмжийн нэрс, хувьсагчууд болон кодын хэсгүүдэд ашиглагдсан.

### **Bold**

**bold** үсгийн маяг нь програмууд, тушаалууд болон товчлууруудад ашиглагдсан.

## Хэрэглэгчийн Оролт

Товчлуурууд нь бусад текстээс ялгарахын тулд **bold** хэлбэрээр харуулагдсан. Товчлууруудын хослолууд нь зэрэг бичигдэх ёстой бөгөөд товчлууруудын хооронд ‘+’ тавигдан үзүүлэгдсэн, жишээ нь:

### **Ctrl+Alt+Del**

Энэ нь хэрэглэгч **Ctrl**, **Alt**, болон **Del** товчлууруудыг зэрэг дарах ёстой гэсэн үг юм.

Дараалан бичих ёстой товчлууруудыг таслалаар тусгаарладаг, жишээ нь:

### **Ctrl+X, Ctrl+S**

Энэ нь хэрэглэгч **Ctrl** болон **X** товчлууруудыг зэрэг дараад дараа нь **Ctrl** болон **S** товчлууруудыг зэрэг дарна гэсэн үг юм.

## Жишээнүүд

E:\> гэж эхэлсэн жишээнүүд нь MS-DOS® тушаалыг илэрхийлнэ. Тэмдэглэж хэлээгүй л бол эдгээр тушаалуудыг орчин үеийн Microsoft Windows орчны “Тушаал хүлээх мөр” цонхноос ажиллуулж болох юм.

```
E:\> tools\fdimage floppies\kern.flp A:
```

# гэж эхэлсэн жишээнүүд нь FreeBSD дээр супер хэрэглэгчээр ажиллуулах ёстой тушаалыг илэрхийлнэ. Тушаал бичихийн тулд та root эрхээр нэвтрэх юм уу эсвэл өөрийн ердийн эрхээр нэвтрээд супер хэрэглэгчийн зөвшөөрлүүдийг авахын тулд su(1)-г ашиглаж болох юм.

```
# dd if=kern.flp of=/dev/fd0
```

% гэж эхэлсэн жишээнүүд нь ердийн хэрэглэгчийн бүртгэлээс ажиллуулах ёстой тушаалыг илэрхийлнэ. Тэмдэглэж хэлээгүй л бол орчны хувьсагчууд болон бусад бүрхүүлийн тушаалуудыг тохируулахад C бүрхүүлийн синтакс ашиглагддаг.

```
% top
```



## Талархал

Таны барьж байгаа ном нь дэлхий даяарх олон зуун хүмүүсийн хүч хөдөлмөр юм. Бичгийн алдаануудын засварууд илгээсэн ч бай эсвэл бүхэл бүтэн бүлгүүдийг ирүүлсэн ч бай гэсэн эдгээр бүх оруулсан хувь нэмрүүд нь их ач холбогдолтой байсан юм.

Зохиогчдыг бүтэн ажлын өдрийн турш ажиллахыг дэмжин цалинжуулж, хэвлэлтийн төлбөрийг төлөх гэх зэргээр хэд хэдэн компаниуд энэ баримтын хөгжүүлэлтийг дэмжсэн билээ. Ялангуяа BSDi-ийн (дараахан нь Wind River Systems (<http://www.windriver.com>) худалдан авсан) цалинжуулсан FreeBSD баримтжуулах төслийн гишүүд энэ номыг сайжруулж бүтэн ажлын өдрийн турш ажилласан нь 2000 оны 3 сард эхний хэвлэгдсэн хувилбар гаргахад хүргэсэн юм (ISBN 1-57176-241-8). Wind River Systems дараа нь хэвлэгдсэн гаралтын дэд бүтцэд хэд хэдэн сайжруулалтуудыг хийлгэж текстэд нэмэлт бүлгүүдийг нэмүүлэхийн тулд хэд хэдэн зохиогчийг цалинжуулсан билээ. 2001 оны 11 сард хэвлэгдсэн хоёр дахь хэвлэлд энэ ажил оржээ (ISBN 1-57176-303-1). 2003-2004 онуудад FreeBSD Mall, Inc (<http://www.freebsdmall.com>) гурав дахь удаагийн хэвлэлийг бэлтгэхэд зориулан Гарын авлагыг сайжруулахын тулд хэд хэдэн хувь нэмэр оруулагчдыг цалинжуулсан юм.

# I. Эхлэл

FreeBSD гарын авлагын энэ хэсэг нь FreeBSD-тэй шинээр танилцаж байгаа администратор болон хэрэглэгчдэд зориулагдсан. Энд гарах бүлгүүд нь:

- FreeBSD-н танилцуулга.
- FreeBSD-г суулгах үйл явц.
- UNIX-ийн үндсийн ойлголт.
- FreeBSD-тэй хамт ирдэг гуравдагч-этгээдийн програмыг хэрхэн суулгах болон
- UNIX цонхот систем X-ийг танд танилцуулж, илүү үр бүтээлтэй ажиллахын тулд ажлын ширээний орчноо хэрхэн тохируулах талаар тайлбарлана.

Бид Гарын авлагынхаа энэ хэсгийг аль болох цөөхөн хуудас дамжихаар бодолцсон бөгөөд ингэснээр танд энэ гарын авлагыг эхнээс нь дуустал хуудаснаас хуудас уруу үсрэлгүйгээр уншиж дуусгахад зориулсан билээ.

# Chapter 1 Танилцуулга

*Датин бүтцийг өөрчилж зохион байгуулсан, зарим хэсгийг датин бичсэн Жим Мок. Орчуулсан Цагаанхүүгийн Ганболд.*

## 1.1 Ерөнхий агуулга

FreeBSD-г сонирхсон танд баярлалаа! Дараах бүлэг FreeBSD төслийн түүх, зорилго, хөгжүүлэх загвар зэрэг бусад төрөл бүрийн ойлголтуудыг хамарна.

Энэ бүлгийг уншсаны дараа, та дараах зүйлсийг мэдэх болно:

- FreeBSD бусад компьютерийн үйлдлийн системүүдтэй ямар хамааралтай талаар.
- FreeBSD төслийн түүх.
- FreeBSD төслийн зорилгууд.
- FreeBSD-ийн нээлттэй-эх хөгжүүлэх загварын үндсүүд.
- Мөн мэдээж “FreeBSD” нэр хаанаас гарсан талаар.

## 1.2 FreeBSD-д тавтай морилно уу!

FreeBSD нь Интел (x86 болон Itanium®), AMD64, Alpha™, Sun UltraSPARC® компьютеруудад зориулагдсан 4.BSD-Lite дээр үндэслэсэн үйлдлийн систем юм. Мөн өөр бусад архитектур уруу порт хийгдэж байгаа болно. Та мөн FreeBSD-ийн түүх эсвэл одоогийн хувилбарыг унших боломжтой. Хэрэв та энэ төсөлд (код, тоног төхөөрөмж, сан) хувь нэмэр оруулахыг сонирхож байгаа бол FreeBSD-д хувь нэмэр оруулах нь ([http://www.FreeBSD.org/doc/mn\\_MN.UTF-8/articles/contributing/index.html](http://www.FreeBSD.org/doc/mn_MN.UTF-8/articles/contributing/index.html)) нийтлэлийг уншина уу.

### 1.2.1 FreeBSD юу хийж чадах вэ?

FreeBSD олон тооны дурдахад буруудахгүй боломжуудтай. Эдгээрийн зарим нь:

- Компьютерийг их ачаалалтай байсан ч програмууд болон хэрэглэгчдийн хооронд бартаагүй, ижил хуваалцах нөхцлийг бүрдүүлэх, динамик дараалал тохируулалттай, *илүү өндөр давуу эрх бүхий бодлогоор солигдох боломж бүхий олон бодлогочлол.*
- *Олон-хэрэглэгчийн боломжууд* нь олон хүмүүс FreeBSD системийг төрөл бүрийн зүйлд зориулан зэрэгцэн хэрэглэх боломжийг зөвшөөрдөг. Энэ нь, жишээ нь, хэвлэгчүүд болон соронзон хальсны хөтлөгчүүд зэрэг системийн захын төхөөрөмжүүд нь систем эсвэл сүлжээн дэх бүх хэрэглэгчдийн дунд зөвөөр хуваалцах ба эх үүсвэр бүр дэх хязгаарууд нь маш чухал системийн эх үүсвэрүүдийг илүү ашиглахаас хамгаалж хэрэглэгчдэд болон бүлэг хэрэглэгчдэд тавигдаж болно гэсэн үг юм.
- SCTP, DHCP, NFS, NIS, PPP, SLIP, IPsec, болон IPv6 зэрэг үйлдвэрлэлийн стандартуудын дэмжлэгтэй, хүчирхэг *TCP/IP сүлжээ*. Энэ нь таны FreeBSD машин бусад үйлдлийн системүүдтэй хялбар харилцан ажиллаж чадахаас гадна мөн NFS (файлд алсаас хандах) цахим захидлын үйлчилгээнүүд зэрэг чухал боломжуудыг хангадаг эсвэл Интернэтэд WWW, FTP, чиглүүлэх эсвэл галт ханын

(аюулгүй байдал) үйлчилгээнүүдийн хамт та өөрийнхөө байгууллагыг байрлуулах Enterprise сервер шиг ажиллаж чадна гэсэн үг юм.

- *Санах ойн хамгаалалт* нь програмууд (эсвэл хэрэглэгчид) өөр хоорондоо нөлөөлөхгүй нөхцлийг хангадаг. Нэг програм сүйрэхэд бусдад аль ч замаар нөлөөлөхгүй.
- FreeBSD нь 32-bit үйлдлийн систем (Альфа дээр 64-bit, Itanium, AMD64, болон UltraSPARC) бөгөөд бүр анхнаасаа эхлэн дизайн хийгдсэн юм.
- Үйлдвэрлэлийн стандарт болох *X Цонхны Систем (X11R7)* нь ердийн VGA карт ба дэлгэцийн үнэнд хэрэглэгчийн график интерфэйсийг (GUI) хангадаг бөгөөд бүрэн эхийн хамт ирдэг.
- Линукс, SCO, SVR4, BSDI ба NetBSD-д зориулан бүтээгдсэн олон програмуудтай *хоёртын нийлэмж*.
- Олон мянган *ажиллахад бэлэн* програмууд FreeBSD-ийн *портууд* болон *багцуудын* цуглуулганд байдаг. Эндээс бүгдийг олж болж байхад яагаад сүлжээнээс хайх хэрэгтэй гэж?
- Олон мянган нэмэлт болон *амархан порт хийх* боломжтой програмууд Интернэтэд байдаг. FreeBSD нь эх кодын хувьд ихэнх олны мэддэг арилжааны UNIX системүүдтэй нийцтэй бөгөөд ихэнх програмуудыг хөрвүүлэхэд хэрэв байгаа бол цөөн өөрчлөлтүүдийг шаарддаг.
- Шаардлагаар хуудасладаг (demand paged) *виртуал санах ой* ба “нийлүүлсэн VM/түр хадгалагч” дизайн нь санах ойн хувьд их хэрэглэдэг програмуудын хүслийг үр ашигтайгаар хангадаг бөгөөд ингэхдээ бусад хэрэглэгчдэд харилцан хариу өгөх боломжийг олгосоор байдаг.
- Олон CPU-тай машинуудад зориулсан *SMP* дэмжлэг.
- C, C++, болон *ФОРТРАН* хөгжүүлэх багажуудын бүрэн бүрэлдэхүүн. Нарийн судалгаа болон хөгжүүлэлтэд зориулсан олон нэмэлт хэлнүүд бас портууд болон багцуудын цуглуулганд байдаг.
- Бүх системд зориулсан *эх код* гэдэг нь та орчноо хамгийн ихээр хянана гэсэн үг юм. Та жинхэнэ нээлттэй системтэй мөртлөө яагаад үйлдвэрлэгчийн буянд хаалттай шийдэлд цоожтой байх ёстой гэж?
- Дэлгэрэнгүй *онлайн баримтжуулалт*.
- *гэх мэт өөр илүү олныг дурдаж болно!*

FreeBSD нь Беркли дэх Калифорнийн Их Сургуулийн Компьютерийн Системийн Судалгааны Бүлгээс (CSRG) гаргасан 4.BSD-Lite хувилбар дээр үндэслэсэн бөгөөд BSD системийн хөгжүүлэлтийн бусдаас ялгаатай уламжлалыг үргэлжлүүлсээр байна. CSRG-ээс гаргасан сайхан ажлаас гадна FreeBSD Төсөл нь жинхэнэ амьдрал дээрх ачааллын үеийн найдвартай болон хамгийн сайн ажиллагааг хангах системийг нарийн тохируулахад олон мянган цагийг зориулжээ. Улам олон арилжааны аваргууд ийм боломжууд, ажиллагаа болон найдвартай байдал бүхий PC үйлдлийн системийг гаргах гэж тэмцэж байхад FreeBSD тэдгээрийг *одоо* санал болгож чадна!

FreeBSD-г ямар хэрэглээнд ашиглах нь зөвхөн таны төсөөллийн хүрээнд байна. Програм хангамжийн хөгжүүлэлтээс эхлээд үйлдвэрлэлийн автоматжуулалт, төлвийн хяналтаас авахуулаад алсын хиймэл дагуулын антеннуудын азимут засварлалт; хэрэв үүнийг арилжааны UNIX бүтээгдэхүүнээр хийж чадах бол мэдээж та үүнийг FreeBSD-ээр ч бас хийж чадна! Мөн FreeBSD дэлхий даяар судалгааны төвүүд болон их сургуулиудад хөгжүүлсэн ихэнхдээ бага эсвэл үнэгүй байдаг олон мянган өндөр чанарын програмуудаас мэдэгдэхүйц үр ашгийг авдаг. Арилжааны програмууд бас байдаг бөгөөд өдөр ирэх тусам их хэмжээгээр нэмэгдэж байна.

FreeBSD-ийн өөрийн эх код ерөнхийдөө байгаа болохоор тусгай програмууд эсвэл төслүүдэд зориулж системийг бараг сонсоогүй хэмжээнд өөрчлөх боломжтой бөгөөд ерөнхийдөө бусад ихэнх том том

арилжааны үйлдвэрлэгчдийн үйлдлийн системүүдэд үүнийг хийх боломжгүй байдаг. Энд FreeBSD-г ашиглаж байгаа хүмүүсийн хэрэглээний зарим нэг байна:

- *Интернэтийн Үйлчилгээнүүд*: FreeBSD дэх хүчирхэг TCP/IP сүлжээ нь төрөл бүрийн Интернэтийн үйлчилгээнүүдэд хамгийн тохирсон тавцан болгодог:
  - FTP серверүүд
  - Дэлхий Даяарх Вэб серверүүд (стандарт эсвэл нууцлаг [SSL])
  - IPv4 болон IPv6 чиглүүлэлт
  - Галт хананууд болон NAT (“IP маскарад хийх”) гарцууд
  - Цахим Захидлын серверүүд
  - USENET Мэдээнүүд эсвэл Зарлалын Самбарын Системүүд
  - гэх мэт өөр илүү олныг дурдаж болно...

Та FreeBSD-тэй байхад хямд 386 ангиллын PC-тэй жижгээс хялбархнаар эхлээд таны Enterprise өсөхийн хэрээр RAID хадгалалт бүхий 4 процессортой Xeon хүртэл шинэчилж болно.

- *Боловсрол*: Та компьютерийн шинжлэх ухаан эсвэл түүнтэй холбоотой инженерчлэлийн салбарын оюунтан уу? Үйлдлийн систем, компьютерийн архитектур болон сүлжээний талаар сурахад FreeBSD-ийн далд хангаж өгдөг боломж шиг илүү сайн арга байхгүй. Чөлөөтэй байдаг хэд хэдэн CAD, математикийн болон графикийн дизайн хийх багцууд нь *өөр бусад* ажлуудыг хийхийн тулд компьютерийг ашигладаг хүмүүст FreeBSD-г илүү их ашигтай болгодог!
- *Судалгаа*: Бүхэл системийн хувьд эх кодтой FreeBSD нь үйлдлийн системүүд болон компьютерийн шижлэх ухааны бусад салбаруудын хувьд судалгааны маш сайн тавцан болдог. FreeBSD-ийн чөлөөтэй байдаг чанар нь алсад байгаа бүлгүүд тусгай лицензийн гэрээ эсвэл нээлттэй форум дээр хэлэлцэж болох хязгааруудад санаа зоволгүйгээр шинэ санаанууд болон хуваалцсан хөгжүүлэлт дээр хамтран ажиллах боломжийг бүрдүүлдэг.
- *Сүлжээ*: Шинэ чиглүүлэгч? Нэрийн сервер (DNS)? Хүмүүсийг дотоод сүлжээнээс гадуур байлгах галт хана хэрэгтэй байна уу? FreeBSD нь ашиглаагүй, буланд хэвтэж байгаа 386 эсвэл 486 PC-г пакет шүүлт хийх сайжруулсан боломжуудтай өргөтгөсөн чиглүүлэгч болгон хялбархан хувиргаж чадна.
- *Х Цонхны ажлын станц*: FreeBSD нь чөлөөтэй байдаг X11 серверийг ашиглан хямд X терминалын шийдэлд зориулсан сайн сонголт болдог. X терминалаас ялгаатай нь хэрэв хүсвэл олон програмуудыг FreeBSD ажиллуулахыг зөвшөөрдөг бөгөөд ингэснээр төв серверийн ачааллыг хөнгөвчилдөг. FreeBSD нь “дискгүй” ачаалж чадсанаар ажлын станцуудыг хямд, амархан удирдах боломжтой болгодог.
- *Програм Хангамжийн Хөгжүүлэлт*: Үндсэн FreeBSD систем нь нийтэд алдаршсан GNU C/C++ хөрвүүлэгч болон алдаа ологч зэрэг програмчлалын үндсэн хэрэгслүүдтэй ирдэг.

FreeBSD нь CD-ROM, DVD, болон нэргүй FTP дээр эх болон хоёртын хэлбэрээр байдаг. FreeBSD-г олж авах талаар дэлгэрэнгүй мэдээллийг Appendix A хаягаас үзнэ үү.

## 1.2.2 FreeBSD-г хэн ашигладаг вэ?

FreeBSD нь дэлхийн IT-ийн ихэнх томоохон компаниудын гаргадаг төхөөрөмжүүд болон бүтээгдэхүүнүүдэд тавцан болон ашиглагддаг:

- Apple (<http://www.apple.com/>)
- Cisco (<http://www.cisco.com/>)
- Juniper (<http://www.juniper.net/>)
- NetApp (<http://www.netapp.com/>)

FreeBSD нь бас интернэт дэх зарим нэг хамгийн томоохон вэб хуудсуудыг ажиллуулдаг:

- Yahoo! (<http://www.yahoo.com/>)
- Yandex (<http://www.yandex.ru/>)
- Apache (<http://www.apache.org/>)
- Rambler (<http://www.rambler.ru/>)
- Sina (<http://www.sina.com/>)
- Pair Networks (<http://www.pair.com/>)
- Sony Japan (<http://www.sony.co.jp/>)
- Netcraft (<http://www.netcraft.com/>)
- NetEase (<http://www.163.com/>)
- Weathernews (<http://www.wni.com/>)
- TELEHOUSE America (<http://www.telehouse.com/>)
- Experts Exchange (<http://www.experts-exchange.com/>)

гэх мэт өөр илүү олон вэб хуудсуудыг дурдаж болно.

## 1.3 FreeBSD Төслийн тухай

Дараах хэсэг төслийн товч түүх, төслийн зорилгууд, болон төслийн хөгжүүлэлтийн загвар зэрэг төслийн тухай зарим нэг мэдээллийг өгнө.

### 1.3.1 FreeBSD-ийн товч түүх

*Хувь нэмэр болгон оруулсан Жордан Хаббард.*

FreeBSD төслийн үүсэл 1993 оны эхэн хэсэгт үүдэлтэй бөгөөд залруулах багцын сүүлийн 3 зохицуулагчид болох Нэйт Вилльямс, Род Граймс болон миний биеийн хамтран гаргасан “Албан ёсны бус 386BSD Залруулах багц” аас хэсэгчилэн хөгжсөн юм.

Бидний анхны зорилго хэд хэдэн асуудлуудыг шийдэхийн тулд 386BSD-ийн дундын хормын хувилбарыг гаргаж авах явдал байсан бөгөөд залруулах багцын механизм үүнийг шийдэж чаддаггүй байлаа. Та нарын зарим нэг нь төслийн ажлын анхны нэр тэр явдалтай холбоотой “386BSD 0.5” эсвэл “386BSD Дундын” гэж байсныг санаж магадгүй юм.

386BSD нь бараг жил орчмын үл ойшоолтоос болж ихээхэн зовж байсан тэр үед хүрсэн Билл Жолицийн үйлдлийн систем байсан юм. Залруулалтын багц нь өдөр өнгөрөх бүр улам эвгүйгээр томорч байсан бөгөөд бид ямар нэг юм хийх ёстойг 100 хувь зөвшөөрч Биллд туслахаар шийдэж

